

**МОНГОЛ УЛС: МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САР
ТУТМЫН ТОЙМ**

2015.02

Үзүүлэлтүүд:

ДНБ 7.8%	ГШХО 2-р сард (88.2) сая ам.доллар	Төсвийн тэнцэл (185.3) тэр бум төгрөг	Инфляци 9.3%	Чанаргүй зээл 10 тэрбум төгрөгөөр өслөө	Валютын нөөц 1327.8 сая ам.доллар
Өсөлтөнд ХАА салбар 14.4%, аж үйлдвэр, барилгын салбар 16.1%, үйлчилгээний салбар 4.8%-иар өссөн нь нөлөөлжээ.	Цэвэр ГШХО өмнөх оны мөн үетэй харьцуулахад 242 сая ам.доллараар буурч, өмнөх сараас 82 сая ам.доллараар буурсан сөрөг дүнтэй гарлаа.	Төсвийн орлого 745.6 тэрбум төгрөг, зарлага 930.9 тэрбум төгрөг, тэнцэл 185.3 тэрбум төгрөгийн алдагдалтай.	Өмнөх сараас 0.4 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 9.3 хувиар өслөө.	Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сараас 10 тэрбум төгрөг буюу 1.5%-иар өсөж 667 тэрбум төгрөгт хүрэв.	Монгол банкны валютын нөөц өмнөх сараас 19.5 хувь буюу 322 сая ам.доллараар буурч 1327.8 сая ам.долларт хүрэв.



Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш
1962 төгрөг



Орон сууцны үнийн индекс
1.173
Өмнөх сараас 0.5%-иар, жилээс 1.4%-иар буурлаа.




Монголбанкны бодлогын хүү 1%-иар нэмэгдэж
13%



Монгол үндэсний уламжлалт баяр болох "Цагаан сар" нь өвөг дээдсийн үеэс уламжлан ирсэн төрт ёсны хамгийн том баяр юм. "Цагаан сар" нь 2015 оны хоёрдугаар сарын 19, 20, 21-ний өдрүүдэд болж өнгөрлөө.

Экспортод гаргадаг гол түүхий эдийн үнэ, хэмжээ

Манай улсын экспортын гол бүтээгдэхүүний сар тутмын экспортын хэмжээ болон дундаж үнийг графикаар, оны эцсийн байдлаар хүснэгтээр үзүүлээ.



Сүүлийн 3 жилийн хугацаанд МУ-ын экспортын түүхий эд (Мянган ам.доллар, тонн)

Голлох бүтээгдэхүүн	2012 он		2013 он		2014 он	
	Тонн	Ам.доллар	Тонн	Ам.доллар	Тонн	Ам.доллар
Чулуун нүүрс	20574	1 880 396	18 194	1 116 153	1 106	850 615
Төмрийн хүдэр	6415	532 509	6725	654 333	8 338	448 378
Зэсийн баяжмал	575	838 780	650	948 951	1 378	2 575 636
Нийт	27564	3 251 685	25 569	2 719 437	10 822	3 874 629

Эх сурвалж: УСХОроо

Хэлэлцээр үргэлжилсээр









"Эрдэнэс Тавантолгой" компанид хөрөнгө оруулах консорциум шалгарч, хэлэлцээрээ эхлүүлээд байгаа билээ. Тавантолгойн II шатны хэлэлцээ үргэжилж байгаа бөгөөд талууд гуравдугаар сард хэлэлцээрийг дуусгахаар төлөвлөжээ. Цагаан сарын баяртай холбогдуулан түр зогсоод байсан хэлэлцээр хоёрдугаар сарын 26-наас үргэлжилсэн юм.

Хуудас 1

САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

2015.02

<p>ДНБ</p>	<p>ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр (2014 оны урьдчилсан гүйцэтгэл) 15.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оныхоос 7.8 хувиар өслөө. Үүнд: ХАА-н салбар 14.4 хувь, аж үйлдвэр, барилгын салбар 16.1 хувь, үйлчилгээний салбар 4.8 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.</p>	 <p>ДНБ</p> <table border="1"> <tr><th>Төгрөг</th><th>Өсөлт (%)</th></tr> <tr><td>4У'13*</td><td>11.6%</td></tr> <tr><td>1У'14*</td><td>7.5%</td></tr> <tr><td>2У'14*</td><td>5.3%</td></tr> <tr><td>3У'14*</td><td>7.0%</td></tr> <tr><td>4У'14*</td><td>7.8%</td></tr> </table>	Төгрөг	Өсөлт (%)	4У'13*	11.6%	1У'14*	7.5%	2У'14*	5.3%	3У'14*	7.0%	4У'14*	7.8%
Төгрөг	Өсөлт (%)													
4У'13*	11.6%													
1У'14*	7.5%													
2У'14*	5.3%													
3У'14*	7.0%													
4У'14*	7.8%													
<p>Төсөв</p>	<p>Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ хоёрдугаар сард 745.6 тэрбум төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 930.9 тэрбум төгрөг, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 185.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 93 тэрбум төгрөгөөр өсөхөд зарлагын өсөлт нь орлогын өсөлтөөс 11 пунктээр илүү байгаа нь нөлөөллөө.</p>	 <p>Төсөв</p> <table border="1"> <tr><th>Төрөг</th><th>02'15</th><th>02'14</th></tr> <tr><td>Орлого</td><td>745.6</td><td>801.7</td></tr> <tr><td>Зардал</td><td>930.9</td><td>801.7</td></tr> <tr><td>Тэнцэл</td><td>185.30</td><td>92.3</td></tr> </table>	Төрөг	02'15	02'14	Орлого	745.6	801.7	Зардал	930.9	801.7	Тэнцэл	185.30	92.3
Төрөг	02'15	02'14												
Орлого	745.6	801.7												
Зардал	930.9	801.7												
Тэнцэл	185.30	92.3												
<p>Валютын хани</p>	<p>Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 2015 оны 2 дугаар сард 1961.75 төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 209.62 төгрөг буюу 12 хувь, өмнөх сар буюу 2015 оны 1 дүгээр сараас 1.5 хувь буюу 29 төгрөгөөр сулраад байна. Энэ нь гадаад валютын гадагшлах урсгал их, ГШХО бага байгаатай холбоотой юм.</p>	 <p>Валютын ханш</p> <p>(төгрөг, хоёрдугаар сарын байдлаар)</p>												
<p>Инфляци</p>	<p>Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2015 оны хоёрдугаар сард өмнөх сарынхаас 0.4 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 9.3 хувиар өслөө. Ерөнхий индекс 2015 оны 2 дугаар сард өмнөх сарынхаас 0.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 0.9 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийнх 0.4 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.</p>	 <p>Инфляци</p> <table border="1"> <tr><th>Төрөг</th><th>02'15</th><th>02'14</th></tr> <tr><td>сарын</td><td>0.4</td><td>0.9</td></tr> <tr><td>оны эхнээс</td><td>1.1</td><td>2.7</td></tr> <tr><td>жилийн</td><td>9.3</td><td>12.2</td></tr> </table>	Төрөг	02'15	02'14	сарын	0.4	0.9	оны эхнээс	1.1	2.7	жилийн	9.3	12.2
Төрөг	02'15	02'14												
сарын	0.4	0.9												
оны эхнээс	1.1	2.7												
жилийн	9.3	12.2												
<p>Гадаад валютын нөөц</p>	<p>Гадаад валютын улсын албан нөөц 2015 оны нэгдүгээр сарын байдлаар 1327.8 сая ам.доллар байв. Энэ нь өмнөх сараас 19.5 хувь буюу 322 сая ам.доллараар, өнгөрсөн оны мөн үеэс 45.7 хувь буюу 1119 сая ам.доллараар тус тус буурсан үзүүлэлттэй юм.</p>	 <p>Нийт албан нөөц</p> <p>(сая, ам.доллар)</p>												
<p>MSE-20 индекс</p>	<p>Үнэт цаасны арилжаагаар 2015 оны 2 дугаар сард 111.6 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 12.9 сая ширхэг үнэт цаас арилжаалагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс гүйлгээ 103.3 тэрбум төгрөг, арилжигдсан үнэт цаас 10.4 сая ширхэг буюу 5.0 дахин өссөн байна. ТОП-20 индекс 2015 оны 2 дугаар сард 14003.5 болж, өмнөх сарынхаас 513.7 нэгжээр буурчээ. Хөрөнгийн бирж дээр үйл ажиллагаа явуулж байгаа ХК-иудын үнэт цаасны нийт үнэлгээ 2-р сард 1.4 их наяд төгрөг болж, өмнөх сарынхаас 12.9 тэрбум төгрөг буюу 0.9 хувиар буурчээ.</p>	 <p>MSE-20 индекс</p>												

* Урьдчилсан гүйцэтгэл; Эх сурвалж УСХ, МБ

* Эх сурвалж Монголбанк

* Монголын хөрөнгийн бирж


САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

Санхүүгийн салбар

2015.02


Мөнгө

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2015 оны хоёрдугаар сарын эцэст 10.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 84.1 тэрбум төгрөг буюу 0.8%-иар буурч, өмнөх оны мөн үеэс 382.7 тэрбум төг буюу 3.9%-иар өсжээ. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө сарын эцэст 775.9 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 43.5 тэрбум төг буюу 5.6%, өмнөх оны мөн үеэс 19.3 тэрбум төг буюу 2.5%-иар өсжээ.



Хадгаламж

Нийт хадгаламж 2015 оны хоёрдугаар сарын эцэст өмнөх сарынхаас 45 тэрбум төгрөг буюу 0.6 хувиар буурч 7515.3 тэрбум төгрөг болов. Энэ нь өмнөх оны мөн үеэс 637.6 тэрбум төгрөг буюу 8.3 хувиар өссөн. Ийнхүү өмнөх сараас нийт хадгаламж буурхад валютын хадгаламж 1.8 хувь буюу 40 тэрбум төгрөг, төгрөгийн хадгаламж 0.1 хувь 5.1 тэрбум төгрөгөөр тус бүр буурсан нь нөлөөлөв.



Зээл

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2015 оны хоёрдугаар сард 12.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 88 тэрбум төгрөг буюу 0.7%-иар, өмнөх оны мөн үеийнхээс 1 их наяд төгрөг буюу 9.1% өслөө. Чанаргүй зээлийн хэмжээ 667 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 1.5% (10 тэрбум төгрөг), өмнөх оны мөн үеэс 11.5%-иар (69 тэрбум төгрөг) өссөн байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ сүүлийн таван сар дараалан өсөөд байна.



Ипотекийн зээл

2015 оны нэгдүгээр сарын байдлаар нийт ипотекийн зээл өмнөх сараас 1.9 хувь (54.2 тэрбум төгрөг), өмнөх оны мөн үеэс 43.4 хувь (877.4 тэрбум төгрөг) -иар нэмэгдэж 2844.6 тэрбум төгрөгт хүрэв. Нэгдүгээр сарын эцэст ипотекийн зээлийн үлдэгдлийн 98.1 хувь нь төгрөгийн, 1.9 хувь нь гадаад валютын зээл байна. Нийт ипотекийн зээлд эзлэх чанаргүй зээл 0.5 хувийг эзэлж байна. 2014 оны жилийн эцсийн байдлаар банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн 77.0 хувийг Улаанбаатар хотод, 23 хувийг хөдөө орон нутагт олгосон. Хөдөө орон нутагт олгосон ипотекийн зээлийн үлдэгдлийн 15.7 хувь буюу 102.5 тэрбум төгрөг Дархан-Уул аймагт, 14.9 хувь буюу 97.1 тэрбум төгрөг Орхон аймагт, 9 хувь буюу 58.7 тэрбум төгрөг Дорноговь аймагт ногдож байна.



* Эх сурвалж Монголбанк


САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2015.02

Гадаад худалдаа

Гадаад худалдаа


2015 оны 2-р сарын худалдааны нийт бараа эргэлт 1215.6 сая ам.доллар, үүнээс экспорт 753.2 сая ам.доллар, импорт 462.4 сая ам.долларт хүрч гадаад худалдааны тэнцэл 290.9 сая ам.долларын ашигтай гарлаа. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 7.3 сая ам.доллар буюу 0.6 хувь, үүний дотор экспортын хэмжээ 158.9 сая ам.доллар буюу 26.7 хувиар өсч, импортын хэмжээ 151.5 сая ам.доллар буюу 24.7 хувиар тус тус буурчээ. Экспорт нэмэгдэхэд эрдэс бүтээгдэхүүн, үнэт чулуу, машин тоног төхөөрөмж, хүнсний бэлэн бүтээгдэхүүний экспорт нөлөөлсөн бол импортын бууралтад машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг гэх мэт бүтээгдэхүүний импорт буурсан нь голлон нөлөөлөв.



* Эх сурвалж ҮСХ, МБ

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

Гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 2015 оны нэгдүгээр сарын эцэст сөрөг дүнтэй буюу (88.2) сая ам.долларын үзүүлэлттэй гарлаа. Энэ нь өмнөх сараас (82) сая ам.доллар буурсан, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 242 сая ам.доллараар буурсан сөрөг үзүүлэлт юм. Үүнд гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгжүүдийн толгой компаниас авсан зээлийн эргэн төлөлт их хэмжээгээр хийгдсэн тул 2015 оны нэгдүгээр сарын эцэст гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал сөрөг дүнтэй гарлаа.



* Эх сурвалж МонголБанк

САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ


2015.02

Монгол Улсын гадаад өр, зээлжих зэрэглэл

Гадаад өр

Засгийн газрын нийт гадаад өр 3.6 тэрбум ам.доллар байна.

2014 оны гуравдугаар улирлын байдлаар Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 20.9 тэрбум доллар байсан. Энэ нь өмнөх оны мөн үеэс 14.6 хувь (2.8 тэрбум ам.доллар), өмнөх улирлаас 5.3 хувь (1 тэрбум ам.доллар) өссөн байна. Нийт өрийн 17 хувийг засгийн газрын өр, 7 хувийг Төвбанкны өр, 7 хувийг хадгаламжийн байгууллагуудын өр, 17 хувийг бусад салбаруудын өр, 52 хувийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна. Төвбанкны нийт өрийн 91 хувийг богино хугацаат, 9 хувийг урт хугацаат өглөг эзэлж байна.



* Эх сурвалж Монголбанк

Засгийн газрын гадаад өрийн 2015-2017 оны төсөөлөл

Тэрбум төгрөг

Үзүүлэлтүүд	2014.09.3 Гүйцэтгэл	2015 он	2016 он	2017 он
ЗГ-ын гадаад зээлийн өр	3,911.50	4,089.20	4,299.10	4,169.30
ЗГ-ын гадаад үнэт цаасны өр	2,760.80	2,625.00	2,550.00	2,490.00
Засгийн газрын баталгаа	2,305.50	2,515.80	2,439.20	1,312.50
Засгийн газрын гадаад өрийн дүн	8,977.80	9,230.00	9,288.30	7,971.80

* Эх сурвалж Сангийн яамнаас гаргадаг тайлан мэдээ

САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2015.02

Гадаад өр, зээлжих зэрэглэл

Зээлжих зэрэглэл	S&P		Fitch	
	Монгол Улс	Тогтвортой	Сөрөг	Сөрөг
	B+		B+	
Огноо	2014.04.29		2013.12.13	

Standard & Poor's 2014 оны 4-р сард Монгол Улсын зээлжих зэрэглэлд өөрчлөлт оруулж урт хугацаанд “BB-” байсныг “B+” болгон бууруулж, богино хугацааны зээлжих зэрэглэлийг “B” болгон тогтоосон. Үүнээс өмнө манай улсын зээлжих зэрэглэл “BB+” гэсэн ангилалд багтаж байсан билээ. S&P : МУ-ын зээлжих зэрэглэлд 2014 оны дөрөвдүгээр сараас хойш өөрчлөлт гараагүй байна. Монгол Улсын зээлжих зэрэглэл буурсан шалтгааныг тэд гадаадын хөрөнгө оруулалт 50 орчим хувиар буурсан, гадаад валютын урсгал багассан, өрийн ачаалал үүсч болох эрсдэлт нөхцөл үүссэнтэй холбон тайлбарлаж байна.

Moody's :

Moody's агентлаг нь зээлжих зэрэглэлийг тогтоохдоо C ангиллаас AAA хүртэл 21 ангилалд зэрэглэл тогтоодог ба мөн хэтийн төлөвийг сөрөг, тогтвортой гэж үнэлдэг юм.

Огноо	Зээлжих зэрэглэл	Хэтийн төлөв
2005 оны 10 дугаар сар 4-нд	B1	Тогтвортой
2009 оны 6 дугаар сарын 10-нд	B1	Сөрөг
2009 оны 10 дугаар сарын 30-нд	B1	Тогтвортой
2014 оны 5 дугаар сарын 26-нд	B1	Сөрөг
2014 оны 7 дугаар сарын 17-нд	B2	Сөрөг

Moody's өнгөрөгч оны 7-р сард Монгол Улсын зээлжих зэрэглэлийг бууруулсан.

Moody's агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг B1 -ээс B 2 сөрөг болгож бууруулсан. Үүний шалтгааныг Монгол Улсын гадаад өрийн хэмжээ сүүлийн жилүүдэд огцом өссөн, инфляци өндөр байгаа нь чанаргүй зээлийн хэмжээг нэмэгдүүлж, банкны системийг бүхэлд нь эрсдэлд оруулах магадлалтай гэж үзжээ. Түүнчлэн гадаад валютын нөөц буурч байгааг эрсдэлд тооцжээ.

Үүний зэрэгцээ Moody's засгийн газрын үнэт цаас гаргагч ба бондын үнэлгээг B1, засгийн газрын дунд хугацаат өрийн бичгийн үнэлгээг B1, мөн богино хугацааны үнэлгээг "not prime" буюу төлбөрийн чадвар сул зэрэглэлд хэвээр үлдээсэн.

Уг шийдвэртэй холбоотойгоор тус агентлагийн зүгээс Монголын Засгийн газрын эзэмшлийн Хөгжлийн банкны зэрэглэлийн ирээдүйн төлөвийг тогтвортойгоос сөрөг болгон бууруулсан ба Хөгжлийн банкны хоёрдогч өглөгийг B1, хоёрдогч дунд хугацаат өрийн бичгийг B1 гэж үнэлсэн юм.

* Эх сурвалж <http://www.moodys.com/>
<http://www.standardandpoors.com/>
<http://www.fitchratings.com/>

САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2015.02

Сарын онцлох үйл явдал

- 02.04-нд** Засгийн газар ээлжит бусаар хуралдаж “Эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэн, Засгийн газрын гишүүдийн гаргасан саналыг тусган УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон юм
- 02.09-нд** Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг Япон улсад ажлын айлчлал хийв. Тэрээр Япон Улсын Ерөнхий сайд Ш.Абэтай уулзаж, Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон Улс хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурав. Айлчлалын үеэр Ерөнхий сайд Ч.Сайханбилэг “Стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх, тухайлбал, цахилгаан станц, төмөр зам барих, төмөрлөг, ган, зэс хайлуулах үйлдвэр байгуулах, мөн хурдны зам, метро барих асуудалд онцгой анхаарч, энэ чиглэлд хамтын ажиллагаагаа эрчимжүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийлэв.
- 02.10-нд** Засгийн газрын хуралдаанаар нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг 10 орчим хувиар нэмэгдүүлэхээр тогтлоо. Тэтгэврийн болон нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн нэмэгдэл нь 2015 оны гуравдугаар сарын тэтгэвэр, тэтгэмж дээр нэмэгдэж олгогдох юм.
- 02.13** Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газраас 2015 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ, байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх зорилгоор “Шилэн тендер-2015” нээлттэй өдөрлөгийг хоёрдугаар сарын 13-ны өдөр зохион байгууллаа.
- 02.15-нд** Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлөөс Монгол Улсын Засгийн газарт “Эрдэнэс Тавантолгой”-н хэлэлцээртэй холбоотой зөвлөмж гаргалаа. Зөвлөмжөөр УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн уялдааг сайжруулж, төслийг саадгүй хэрэгжүүлэх, Хөрөнгө оруулалтын гэрээг байгуулах, иргэдэд олгосон “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг эдийн засгийн эргэлтэд оруулах, хэлэлцээний явц үр дүнг, УИХ болон олон нийтэд танилцуулж байх үүргийг өгчээ.
- 02.16-нд** Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржид хоёрдугаар сарын 16-нд ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын дарга Сергей Евгеньевич Нарышкин бараалхав. ОХУ-ын Ерөнхийлөгчийн өнгөрсөн жил Монголд айлчлах үеэр гарын үсэг зурсан баримт бичгүүд болон яриа, хэлэлцээнүүдийг ажил хэрэг болгох талаар хоёр тал анхааран ажиллаж байгааг ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын дарга Сергей Евгеньевич Нарышкин тэмдэглэж байлаа.
- 02.19-02.21-нд** Монгол үндэсний уламжлалт баяр болох "Цагаан сар" нь өвөг дээдсийн үеэс уламжлан ирсэн төрт ёсны хамгийн том баяр билээ. "Цагаан сар" нь 2015 оны хоёрдугаар сарын 19, 20, 21-ны өдрүүдэд болж улс даяараа амарч үндэсний баяраа тэмдэглэлээ.
- 02.23-02.27** Монгол Улсын Их Хурлын дарга Зандаахүүгийн Энхболд Япон Улсын парламентын Төлөөлөгчдийн танхимын дарга Н.Мачимурагийн урилгаар 2015 оны 2 дугаар сарын 23-27-ны өдрүүдэд тус улсад албан ёсны айлчлал хийлээ.

оны хоёрдугаар сарын 18-ны УИХ-ын чуулганаар “Эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоолын төслийг мөн Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль, Өрийн удирдлагын тухай болон холбогдох бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийн тус тус баталлаа.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2015 оны хоёрдугаар сарын 26-нд зарим хүнд уучлал үзүүлж, эдлээгүй үлдсэн хорих ялаас бүрэн чөлөөлөв. Татвар төлөхөөс зайлсхийсэн хэргээр ял эдэлж байсан АНУ-ын иргэн Жастин Капла, Бүгд найрамдах Филиппин улсын иргэн Кристобал Ж.Дэвид, мөн улсын иргэн Хилармон В.Кажуком ЖР нарт Монгол Улсын Ерөнхийлөгч уучлал үзүүллээ.

Жил бүр Азийн Хөгжлийн Банкнаас гаргадаг “Азийн Хөгжлийн Төлөв 2015” эдийн засгийн тайлан 2015 гуравдугаар сарын 24-нд гарчээ. “Азийн Хөгжлийн Төлөв 2015” тайланд Азийн хөгжиж буй улс орнуудын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 2015-2016 онуудад 2014 оны адил 6.3% байна гэсэн бол Монгол Улсын хувьд 2015 онд 3 хувь, 2016 онд 5 хувь болж буурна хэмээн тооцоолж Азийн бусад улс орноос өсөлтөөрөө хоцрох төлөвтэй, гадаад орчин тогтвортой байж, 2015 онд уул уурхайн томоохон хөрөнгө оруулалт сэргэнэ гэсэн таамаглалаар, 2016 онд эдийн засгийн өсөлт 5% болж нэмэгдэх боломжтой гэж тайланд дурьджээ.

Судалгааны тайлангийн тухай :

Өмнөх саруудын тайланг www.ecrc.mn вэб сайтаар орон авах боломжтой.

Холбоо барих хаяг:

Утас : 976-11-321927

Факс: 976-11-321926

Вэб сайт: www.ecrc.mn

www.aimagindex.mn

Email: info@ecrc.mn